

ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭ

1. Гэрээ байгуулагч Талууд:

1.1. Нэг талаас: Төсвийн ерөнхийлөн захирагч

Нийслэлийн Засаг дарга бөгөөд

Улаанбаатар хотын Захирагч

(албан тушаал, нэр)

С.Амарсайхан

(эцэг/эх/-ийн нэр, нэр)

1.2. Нөгөө талаас: Төсвийн шууд захирагч

Налайхын барилгын үйлдвэрлэл,

технологийн паркийн дарга

(албан тушаал)

С.Батжаргал

(эцэг/эх/-ийн нэр, нэр)

бид дор дурдсан асуудлаар харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

2. Гэрээний агуулга, зорилго

2.1 Энэхүү гэрээний зорилго нь төсөв болон эд хөрөнгийг зохистой ашиглах, төсвийн үр дүнг сайжруулах, төсвийн шууд захирагчийн тухайн жилд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлоход оршино.

2.2 "Төсвийн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө" нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.

НЭГ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

1. Төсвийн шууд захирагчийн хүлээх үүрэг

1.1. Энэхүү гэрээний хавсралт болох "Төсвийн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө"-нд тусгагдсан 3 нийт арга хэмжээ, 11,117,820,000 Арван нэг тэрбум нэг зуун арван долоон сая найман зуун ачирин мянган төгрөг байна

1.2. Үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон өөрийн эрхлэх асуудлын хүрээний холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

1.3. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж ажиллана.

1.4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

1.5 Байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл, үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцаж ажиллана.

2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг

2.1. Төсвийн шууд захирагчтай байгуулах гэрээнд тусгаж хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнүүдийг тодорхойлно.

2.2. Тухайн төрийн байгууллага болон эрх шилжүүлсний үндсэн дээр бусад байгууллага хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай төсвийг эрх бүхий байгууллагаар батлуулна.

2.3 Тухайн төрийн байгууллага болон эрх шилжүүлсний үндсэн дээр бусад байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг хугацаанд нь хийнэ.

2.4 Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

ХОЁР. БУСАД ЗҮЙЛ

3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

3.1 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэж, албажуулан гэрээнд хавсаргана. Энэхүү гэрээний хугацаа сунгагдахгүй.

4. Гэрээний урамшуулал ба хариуцлага

4.1 Төсвийн шууд захирагч гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн тохиолдолд түүнийг урамшуулах асуудлыг Төсвийн ерөнхийлөн захирагч Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт, журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

4.2 Төсвийн шууд захирагч нь Төсвийн Ерөнхийлөн захирагчтай байгуулсан энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн эсвэл гэрээний биелэлтээ тайлагнаагүй бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5. Гэрээ байгуулах болон дүгнэх хугацаа

5.1. Гэрээг 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацаагаар байгуулав.

5.2. Төсвийн шууд захирагч гэрээний биелэлтийг 2021 оны 01 дүгээр сарын 05-ны дотор багтаан тайлагнаж, төсвийн ерөнхийлөн захирагч 2021 оны 01 дүгээр сарын 15-ны дотор багтаан түүний биелэлтийг дүгнэнэ.

Гэрээ байгуулсан:


Төсвийн ерөнхийлөн захирагч

Нийслэлийн Засаг дарга бөгөөд

Улаанбаатар хотын Захирагч

(албан тушаал)

Тэмдэг





/С.Амарсайхан/

(гарын үсэг)

(огноо)

Төсвийн шууд захирагч



/С.Батморгал/

(гарын үсэг)

(албан тушаал)

Тэмдэг

(огноо)


“Налайхын барилгын материалын үйлдвэрлэл,
технологийн парк” ОНӨТҮГ-ын Үр дүнгийн гэрээний хавсралт

ТӨСВИЙН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв /сая.төгрөгөөр	Хэрэгжүүлэх хугацаа	Хүрэх үр дүн
1	Паркийн 110кВ-ийн цахилгаан хангамжийн 1, 2-р ээлжийн бүтээн байгуулалтын дэд станцын барилгын ажлыг зохион байгуулна.	5,257.50 Нийслэлийн төсөв	Жилдээ	Дэд станцын барилгы ашиглалтанд орсон. 50%
2	Замын-Үүд – Чойрын замаас Парк хүртэлх гадна 4,64км авто замыг ашиглалтанд оруулна	5,513.70 Нийслэлийн төсөв	Жилдээ	4,64 км авто зам ашиглалтанд орж үйлдвэрүүдийн хүнд даацын машин зорчих боломжтой болсон.
3	УРСГАЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ	346.62	2020	Тайлант хугацаанд төсвийн зардлыг хэтрүүлэхгүй, өр авлага үүсгэхгүй зохистой зарцуулна.
3.1	Ажилчдын цалин хөлсийг хугацаанд нь олгох	196.54	I-IV улирал	Ажилтан албан хагчдын цалин хөлсийг сард 2 удаа бодож олгоно.
3.2	Нийгмийн даатгалын шимтгэлийг хугацаанд нь төлөх	26.53	I-IV улирал	Нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр шилжүүлэн, тайлан гаргаж, ажилчдын нийгмийн даатгалын дэвтрийг баталгаажуулна.
3.3	Ажлын байрны тав тухтай орчныг бүрдүүлэх	25.22	I-IV улирал	Ажилтан албан хаагчдыг ажиллах таатай нөхцөл боломжоор ханган ажиллана.
3.4	Паркийн оффисийн барилгын ашиглалтын зардлыг хэмнэлттэй зохистой зарцуулах	40.41	I-IV улирал	Төсөв санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөн зардлыг хэмнэн өр авлага үүсгэхгүй ажиллана.
3.5	Техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах	4.1	I-IV улирал	Эвдрэл гэмтлийг тухай бүр засварлаж, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллана.
3.6	Ажилтан албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх, сургалтанд хамруулах	0.48	I-IV улирал	Хүний нөөцийн чадавхийг дээшлүүлж, ажлын бүтээмж нэмэгдэнэ.

3.7	Бусад паркуудтай хамтран уулзалт, өдөрлөг зохион байгуулах, туршлага судлах	2.25	I-IV улирал	Бусад паркуудын ажлын туршлагаас судлан цаашид хэрхэн хамтарч ажиллах, паркийг хөгжүүлэх талаар туршлага солилцох
3.8	Байгууллагын тохижилт, өнгө үзэмжийг сайжруулах, объектийн аюулгүй ажиллагааг ханган ажиллах.	49.12	I-IV улирал	Паркийн өнгө үзэмж сайжирч, объектийн аюулгүй ажиллах нөхцөл боломж бүрдсэн байна.
3.9	Албан хаагчдын нийгмийн халамжийн асуудлыг шийдвэрлэх	2.00	I-IV улирал	Албан хаагчдын нийгмийн халамжийн асуудлыг тодорхой түвшинд шийдвэрлэсэн байна.
	Нийслэлийн хөрөнгө оруулалтын ажил	10.771.2		
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	346.62		
4	Нийт дүн	11,117.82		

Төсвийн шууд захирагч



С.БАТЖАРГАЛ

/Гарын үсэг, тэмдэг/

ТӨСВИЙН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

д/д	Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв /сая.төгрөгөөр	Хэрэгжүүлэх хугацаа	Хүрэх үр дүн	Биелэлт
1	Паркийн 110кВ-ийн цахилгаан хангамжийн 1, 2-р ээлжийн бүтээн байгуулалтын дэд станцын барилгын ажлыг зохион байгуулна.	5,257.50 Нийслэлийн төсөв	Жилдээ	Дэд станцын барилгы ашиглалтанд орсон. 50%	<ul style="list-style-type: none"> • 110/10 кВ-ын үндсэн цахилгаан хангамжийн 2х16 кВА-ын дэд станц, удирдлагын байрыг барьж байгуулах сонгон шалгаруулалтанд шалгарсан “Хасу-Эрчим” ХХК 2020.04.29-ний өдөр бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлсэн ба барилгын ажил хийгдэж дууссан, тоног төхөөрөмжөө суурилуулан бэлэн болоод байна. • 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажлын сонгон шалгаруулалтаар “Вилл вест” ХХК шалгаран 2020.07.27-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж байна. 2020 онд 4 хуваарилах байгууламжийн барилга угсралтын ажил болон паркийн талбай дээрх 10 кВ-ын цахилгааны утас татах зэрэг ажлууд хийгдсэн. /100%/
2	Замын-Үүд – Чойрын замаас Парк хүртэлх гадна 4,64км авто замыг ашиглалтанд оруулна	5,513.70 Нийслэлийн төсөв	Жилдээ	4,64 км авто зам ашиглалтанд орж үйлдвэрүүдийн хүнд даацын машин зорчих боломжтой болсон.	<ul style="list-style-type: none"> • 2020.10.14-ны өдрийн ЗБХХ-2020/14 дугаар “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркаас Налайх Чойрын авто замтай холбох авто замыг ашиглалтанд авах ажлын хэсгийн акт, дүгнэлт” гаран ашиглалтад хүлээн авсан.
3	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	346.62	2020	Тайлант хугацаанд төсвийн зардлыг хэтрүүлэхгүй, өр авлага үүсгэхгүй зохистой зарцуулна.	Тайлант хугацаанд тэвчиж болох зардлыг гаргахгүй байхад анхаарч, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан хэмнэлтийн горимоор ажилласан.
3.1	Ажилчдын цалин хөлсийг хугацаанд нь олгох	196.54	I-IV улирал	Ажилтан албан хаагчдын цалин хөлсийг сард 2 удаа бодож олгоно.	Ажилтан албан хаагчдын цалин хөлсийг сард 2 удаа тооцож олгосон. Гүйцэтгэлээр цалингийн зардал 195.89 төгрөг гарсан.
3.2	Нийгмийн даатгалын шимтгэлийг хугацаанд нь төлөх	26.53	I-IV улирал	Нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр шилжүүлэн, тайлан гаргаж, ажилчдын нийгмийн даатгалын дэвтрийг баталгаажуулна.	Нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр төлж, өр авлага үүсгэхгүй ажилласан. Байгууллагаас төлсөн НДШ зардал гүйцэтгэл 24.48 сая төгрөгийн зардал гарсан.

3.3	Ажлын байрны тав тухтай орчныг бүрдүүлэх	25.22	I-IV улирал	Ажилтан албан хаагчдыг ажиллах таатай нөхцөл боломжоор ханган ажиллана.	Албан хаагчдын тав тухтай орчинг бүрдүүлэн техник хангамж болон бичиг хэргийн материалаар бүрэн хангаж ажилласан.
3.4	Паркийн оффисийн барилгын ашиглалтын зардлыг хэмнэлттэй зохистой зарцуулах	40.41	I-IV улирал	Төсөв санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөн зардлыг хэмнэн өр авлага үүсгэхгүй ажиллана.	Нийт ашиглалтын зардал 29,58 сая төгрөг. Зардал хэмнэх үүднээс цахилгааны зарцуулалтыг багасгаж, оффисийн барилгын 2 давхрын цахилгаан халаалтыг ажиллуулаагүй учир 10,9 сая төгрөгийн хэмнэлт хийсэн байна.
3.5	Техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах	4.1	I-IV улирал	Эвдрэл гэмтлийг тухай бүр засварлаж, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллана.	Ковид-19 цар тахлын улмаас зарим зардлын эрхийг сангийн яамнаас хязгаарласан учир засвар, үйлчилгээ хийгдээгүй.
3.6	Ажилтан албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх, сургалтанд хамруулах	0.48	I-IV улирал	Хүний нөөцийн чадавхийг дээшлүүлж, ажлын бүтээмж нэмэгдэнэ.	<ul style="list-style-type: none"> • 2020 оны Хүний нөөцийн сургалт, хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан доорх сургалтуудыг танхимаар болон цахим хэлбэрээр явуулсан. Сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулсан: <ul style="list-style-type: none"> - Нэг хот-Нэг стандартын жилийн хүрээнд "Чанарын удирдлагын тогтолцооны /ISO9001/ олон улсын стандартын сургалтыг "Олон улсын стандартын академи"-аас авсан Албан хаагчдын зохион байгуулсан: <ul style="list-style-type: none"> - Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн анхан шатны сургалт - Солонгос хэлний анхан шатны сургалт - Эдок системд албан бичигтэй ажиллах, шийдвэрлэлтийг оновчтой зөв гүйцэтгэх талаар зөвлөгөө, мэдээлэл - Нэрийн хуудасны хэрэглээ - Шинэчлэгдсэн Хөдөлмөрийн дотоод журам, өөрчлөлт орсон зүйл заалтын талаарх мэдээлэл - Авлигын тухай сургалт • Швейцарын хөгжлийн агентлаг, ХБНГУ-ын Холбооны эдийн засаг, хөгжлийн яамны хамтарсан санхүүжилтээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Германы олон улсын хамтын ажиллагааны

					нийгэмлэг /GIZ/-ээс хамтран хэрэгжүүлж буй “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хүрээнд Нийслэлийн сургалт судалгааны төвөөс зохион байгуулсан “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага”, “Ашиглалтын хугацааны зардал” сургалтанд 2 албан хаагчийг хамруулсан.
3.7	Бусад паркуудтай хамтран уулзалт, өдөрлөг зохион байгуулах, туршлага судлах	2.25	I-IV улирал	Бусад паркуудын ажлын туршлагаас судлан цаашид хэрхэн хамтарч ажиллах, паркийг хөгжүүлэх талаар туршлага солилцох	<ul style="list-style-type: none"> • COVID-19 цар тахлын улмаас хилийн хориг тогтоосонтой холбоотой гадаадын үйлдвэрлэл, технологийн паркттай танилцах, туршлага солилцох ажлууд хийглээгүй бөгөөд гадаад болон дотоодын ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг паркуудтай туршлага солилцох зорилгоор Солонгосын ҮТП-тай хамтран ажиллах боломжийг судалж байна. • 2020 онд нийт 23 аж ахуйн нэгж, иргэд, дээд газрын удирдлагуудтай уулзалт, зөвлөгөөн зохион байгуулснаас. <ul style="list-style-type: none"> - Гадаадын 7 - Дотоодын 16
3.8	Байгууллагын тохижилт, өнгө үзэмжийг сайжруулах, объектийн аюулгүй ажиллагааг ханган ажиллах.	49.12	I-IV улирал	Паркийн өнгө үзэмж сайжирч, объектийн аюулгүй ажиллах нөхцөл боломж бүрдсэн байна.	Аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллахаас гадна галдны тохижилтын ажлыг улирал бүр хийн ажиллаж байна.
3.9	Албан хаагчдын нийгмийн халамжийн асуудлыг шийдвэрлэх	2.00	I-IV улирал	Албан хаагчдын нийгмийн халамжийн асуудлыг тодорхой түвшинд шийдвэрлэсэн байна.	<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн хуулийн дагуу 4 ажилтанд ээлжийн амралт • Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг сар, улирлаар холбогдох журмын дагуу үнэлж ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг олгосон. • Ар гэрийн гачигдал гарсан 1, шинэ хүүхэдтэй болсон 1 албан хаагчид тус тус 300,000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон. • Тухайн онд ажлын үр бүтээлтэй, хамт олноо манлайлан ажилласан 5 албан хаагчийн төрийн дээд болон салбар, нийслэлийн шагналд өргөн мэдүүлсэн шагналын анкетийг холбогдох газруудад хүргүүлж үүнээс:

- | | | | | |
|--|--|--|--|--|
| | | | | <ul style="list-style-type: none">• Төрийн дээд Алтангадас одон 1, Хөдөлмөрийн хүндэт тэмдэгээр 1 албан хаагчийг шагнуулсан• Эх үрсийн баярыг тохиолдуулан байгууллагын албан хаагчдын 0-16 насны 25 хүүхдүүдэд нийт 400 000 төгрөгийн гарын бэлэг• Сар, улирлын ур чадварын нэмэгдэл болон үр дүнгийн урамшуулалыг ур чадварын нэмэгдэл олгох журмын дагуу тооцон олгосон• Нийслэлийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн Урамшуулал олгох тухай А/342 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах, сайжруулсан түлшний зөв хэрэглээх нэвтрүүлэх, заавар зөвлөмж хүргэх болон дэлхий нийтийг хамарсан шинэ төрлийн Коронавирус гарч халдвараас иргэд, олон нийтийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын онцгой дэглэм тогтоосонтой холбогдуулан болзошгүй эрсдэлээс сэрэмжлүүлэх, иргэдийн хөл хөдөлгөөнийг хязгаарлахад хяналт тавих үйл ажиллагаанд идэвх санаачлагатай ажилласан албан хаагчдад урамшуулал олгосон• Засгийн газрын 2020 оны “Шинэ коронавирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол, “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 64 дүгээр тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны “Иргэд, зорчигч тээврийн хөдөлгөөнийг хязгаарлах тухай” 6 дугаар тогтоолын дагуу 0-12 насны хүүхэдтэй эхчүүдэд цалинтай чөлөө олгож, гэрээс нь ажиллах боломжоор хангасан.• “Супер нова” шинжилгээний төвтэй хамтран байгууллагын 10 ажилтныг Эрдэс витаминь багц шинжилгээнд хамруулсан. |
|--|--|--|--|--|